

**“ТУСГАЙ ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт заасны дагуу “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дахин авч хэлэлцлээ.

Тус Байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн, Улсын Их Хурал дахь Ардчилсан Намын бүлгийн дарга О.Цогтгэрэлээс Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр томилуулах тухай ирүүлсэн саналыг хэлэлцэж дэмжсэн бөгөөд Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн юм.

Дээрх Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үед Улсын Их Хурал дахь Ардчилсан Намын бүлгийн дарга О.Цогтгэрэлээс Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг бүлгээрээ дахин зөвшилцөх шаардлагатай байгаа тул завсарлага авах санал гаргасан тул хэлэлцүүлэг хойшлогдсон.

Улсын Их Хурал дахь Ардчилсан Намын бүлгийн дарга О.Цогтгэрэл 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд завсарлагааны хугацаа дуусгавар болсноо мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт тус намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбатыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр томилуулах тухай саналаа ирүүлсэн тул энэ асуудлыг дахин хэлэлцүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа Дэд хорооны гишүүнд дэвшүүлсэн өөрийн нэрээ татан авснаа мэдэгдээд, Тусгай хяналтын дэд хорооны гишүүдээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хар тамхитай тэмцэх талаар гаргаж байгаа саналыг нь дэмжиж, хэлэлцэж өгөхийг хүссэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Дашдондогийн Ганбат нарыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр томилохыг дэмжсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсэгт заасны дагуу Байнгын хорооноос боловсруулсан Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэж, уг тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХ-АМГАЛАН

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Дашдондогийн Ганбат нарыг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр баталсугай.

2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг